

## **Аж ахуйн нэгж, байгууллагуудын татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх нь**

### **Detecting Tax Avoidance in Entities**

Э. Цэцэгдэлгэр<sup>1</sup>, Б. Алтан-Эрдэнэ<sup>2</sup>

#### Хураангуй

Бид Dyreng (2008) нарын боловсруулсан татварын үр ашигтай хувь хэмжээний загвар ашиглан манай улсад үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийж буй эсэхийг илрүүлэхийг зорьсон. Судалгааны түүвэрт 2013 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байсан нийт 47,557 аж ахуйн нэгжээс загварын шалгуурын дагуу 2013-2019 оны хооронд тасралтгүй үйл ажиллагаа явуулж, татвар төлсөн 2,853 аж ахуйн нэгж сонгогдсон. Тооцооллын үр дүнд аж ахуйн нэгжийн хэмжээ, байршил, бүс нутгийн ялгаанаас үл хамаарч эдгээр аж ахуйн нэгжүүдийн 90-ээс дээш хувь нь татвараас тогтвортой зайлсхийж буй нь харагдсан.

*Түлхүүр үгс:* татвараас зайлсхийх, татварын үр ашигтай хувь хэмжээ

#### Abstract

We examine tax avoidance activity of all operating entities in our country employing a long-run CASH ETR measure developed by Dyreng et al. (2008). According to the requirement of this measurement, 2,853 unique entities that are consistently operated and have an unbroken string of cash taxes paid are chosen as a sample of aggregate 47,557 entities covered by the years 2013-2019. We find that the immense amount of our sample, such as more than 90 percent of all entities, successfully avoid taxes for the long run regardless of their size, location, and area.

*Keywords:* tax avoidance, effective tax rate (ETR)

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим  
E-mail: tsetsegdelger@num.edu.mn

<sup>2</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим  
E-mail: altanerdene.b@num.edu.mn

## Удиртгал

Татвараас зайлсхийх байдлыг эдийн засгийн тодорхой хэмжигдэхүүнээр үнэлж хэмжихгүйгээр таамаглан, дүгнэх боломжгүй. Мөн түүнд макро болон микро түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг үндэслэлтэй тооцож, цаашид авах арга хэмжээ, хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах нь зүйтэй. Энэ чиглэлийн судалгаа одоогоор манай улсын хувьд хараахан хийгдээгүй байгаа нь бидний уг ажлыг хийж эхлүүлэх нэг шалтгаан болсон. Энэхүү ажлын гол зорилго бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийж буй эсэхийг Dugeng (2008) нарын боловсруулсан татварын үр ашигтай (Effective Tax Rate-ETR) хувь хэмжээний загвар ашиглан тооцох явдал юм.

Татвараас зайлсхийх байдлын талаар нэгдсэн ойлголт одоогоор тогтоогүй байгаа нь энэ салбарын судлаачдад тулгардаг сорилтуудын нэг хэдий ч энэ чиглэлийн судалгааны ажлуудад нийтлэгээр нийт татварын хэмжээг санаатайгаар болон татварын хуулийн тодорхой бус заалтуудаас шалтгаалж бууруулах явдал гэж үздэг (Hanlon, 2010). Онолын хувьд татвараас зайлсхийх байдлыг татварын хувь хэмжээ, татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх магадлал, оногдуулсан шийтгэл, оноосон алданги торгууль цаашлаад хувь хүн болон хуулийн этгээдийн үүрэг хариуцлага зэргээр тодорхойлдог (Allingham & Sandmo, 1972). Эдгээрээс гадна аж ахуйн нэгжийн өмчлөл ба хяналт (хувьцаа эзэмшигч ба гүйцэтгэх удирдлага) тусдаа байдаг асуудал нь татвараас зайлсхийх байдалд нөлөөлөх бас нэг гол хүчин зүйл гэж үздэг (Slemrod, 2004). Chen & Chu (2005), Crocker &

Slemrod (2005) нарын эрдэмтэд аж ахуйн нэгжийн өмчлөл ба хяналтын түвшин дэх татвараас зайлсхийх байдлын онолын үндсийг тавьсан бөгөөд Chen & Chu (2005) нар татвараас зайлсхийх байдалд өмчлөл ба хяналтын уялдаа холбоо хэрхэн нөлөөлж буй асуудлыг судлахдаа аж ахуйн нэгжүүд татварын тайлагналтай холбоотой шийдвэр гаргахдаа уг асуудлыг авч үздэггүй гэж дүгнэсэн. Нөгөө талаас татварын хуулийн хэрэгжилт, компанийн засаглалын асуудал татвараас зайлсхийх байдалд салшгүй нөлөөтэй болохыг Desai (2007) нарын эрдэмтэд баталсан. Тухайлбал, татварын хувь хэмжээ их боловч хуулийн хэрэгжилт муу бол гүйцэтгэх удирдлага хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өөрт ашигтайгаар удирдах, мөн өөрт таатай татварын шийдвэр гаргадаг. Харин хуулийн хэрэгжилт сайн бол хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө үр ашигтай зохицуулагдаж, татвар төлөлт нэмэгддэг гэж үзсэн. Мөн аж ахуйн нэгжийн татварын хувь хэмжээ өөрчлөгдөхөд тэдгээрийн үзүүлэх хариу арга хэмжээ компанийн засаглал сайн аж ахуйн нэгжүүдийн хувьд нөлөөлөхүйц, муу аж ахуйн нэгжүүдийн хувьд нөлөө багатай гэсэн таамаглалыг улс хоорондын татварын хувь хэмжээний харьцуулсан судалгаануудаараа тус тус баталсан.

Татвараас зайлсхийх байдлыг үнэлэх олон арга, загварууд байдаг хэдий ч судалгааны ажлын зорилго, онцлогоос хамаарч тохирох аргыг сонгох нь зүйтэй (Hanlon, 2010). Эдгээрээс санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн тооцох боломжтой татварын үр ашигтай хувь хэмжээний загварууд; татварын түр, байнгын болон нийт зөрүү гэх мэт үзүүлэлтүүдийг тооцож татвараас зайлсхийх байдлыг үнэлэх зэрэг загварууд нь судалгаанд өргөн

ашиглагддаг. Тухайлбал, татварын үр ашигтай хувь хэмжээний загварууд нь тайлант үеийн татварын зардал болон төлсөн татварын хэмжээнд үндэслэн богино болон урт хугацаанд аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлыг үнэлдэг. Иймд, бид санхүүгийн тайлангийн мэдээллийн олдоцтой байдлыг харгалзан үзэж тайлант хугацаанд төлсөн татварын хэмжээнд үндэслэсэн загварыг сонгон нийт аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлыг илрүүлэхийг зорьсон билээ.

Татвараас зайлсхийх байдлыг үнэлсэн эмпирик судалгаа одоогоор манай улсын хувьд хийгдээгүй байна. Харин бусад улсын хувьд аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлыг илрүүлэх тал дээр хийгдсэн судалгааны ажлууд нилээд урт дараалал үүсгэх бөгөөд түгээмэл загваруудыг ашиглан үнэлсэн хоёр чиглэлийн ажил байна. Эхний бүлэг судалгаанд татварын үр ашигтай хувь хэмжээ (жил бүрээрх)-ний өөрчлөлтийг тооцож татвараас зайлсхийх байдлыг илрүүлэн түүнд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг үнэлсэн ажлууд хамаарах бол, дараагийн хэсэгт татварын түр болон байнгын зөрүүг ихээр тайлагнасан аж ахуйн нэгжүүд мөн татвараас зайлсхийдэг байх магадлалыг үнэлсэн ажлууд багтана.

Дээрх хоёр чиглэлийн судалгаанаас татварын үр ашигтай хувь хэмжээг тооцож түүнд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг үнэлсэн ажлууд нь түгээмэл байдаг [Callihan (1994), Shackelford (2001)]. Тухайлбал, Dureng (2008) нар аж ахуйн нэгжүүдийн тухайн тайлант хугацаанд төлсөн татварын хэмжээг ашиглан татварын үр ашигтай хувь хэмжээг урт хугацаанд буюу арван жилээр тооцох загвар боловсруулж, татвараас зайлсхийх

байдлыг үнэлсэн. Тэрээр татварын үр ашигтай хувь хэмжээ нь 20 хувь болон түүнээс бага аж ахуйн нэгжүүдийг “хамгийн бага” гэсэн ангилалд хамааруулж татвараас тогтвортой зайлсхийж буй гэж таамагласан. Судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжүүдийн 26.3 хувь нь татварын үр ашигтай хувь хэмжээг 20 хувь болон түүнээс бага, 9.2 хувь нь 10 хувиас бага хэмжээнд барьж байсан нь тэдгээр аж ахуйн нэгжүүдийг урт хугацаанд татвараас тогтвортой зайлсхийж байгааг нотолсон. Харин Zimmerman (1983) нар татвараас зайлсхийх байдалд нөлөөлсөн хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэхдээ аж ахуйн нэгжийн хөрөнгийн хэмжээ болон татварын үр ашигтай хувь хэмжээний хоорондын хамаарлыг судалсан. Судалгааны үр дүн эерэг хамаарлыг харуулсан нь томоохон аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад жижиг ах ахуйн нэгжүүд татвараас илүү зайлсхийдэг болох нь тогтоогдсон. Мөн Stickney (1982) нар татварын үр ашигтай хувь хэмжээ бага аж ахуйн нэгжүүд санхүүгийн хөшүүрэг, эдийн засгийн нөөц ихээр шаарддагаас гадна эдгээр нь ихэвчлэн ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд болохыг тогтоожээ. Үүнээс гадна АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнууд улс төрийн зорилгоор татварын үр ашигтай хувь хэмжээг тооцож, түүний үр дүнд үндэслэн татварын хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан байдаг. Жишээ нь: АНУ-ын Citizens for Tax Justice (CTJ) байгууллага аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлыг үнэлэхдээ татварын үр ашигтай хувь хэмжээний загварыг ашигласан бөгөөд судалгааны үр дүнд тус улсын томоохон аж ахуйн нэгжүүд татварынхаа ихэнх хэсгийг төлөхөөс зайлсхийдэг (бултдаг) болох

нь тогтоогдсон. Уг ажлын үр дүн АНУ-ын түүхэнд хамгийн томд тооцогдох 1986 оны татварын реформ хийгдэхэд ихээхэн нөлөөлснийг зарим судлаачид онцолсон байдаг.

Mills (1998) нар татварын зөрүү ихээр тайлагнасан аж ахуйн нэгжүүдэд аудитын шалгалт илүү нарийн хийгдэх магадлалтай байдаг талаар, Wilson (2009) нар татвараас зайлсхийсэн аж ахуйн нэгжүүдийн татварын зөрүү их байсан талаар тус тус судалсан ба уг зөрүүгээр татвараас зайлсхийх байдлын зарим элементийг таних боломжтой хэдий ч бүхэлд нь үнэлэх боломжгүй болохыг харуулсан.

Бид энэхүү судалгааны ажлыг хийж эхлүүлснээр дараах салбаруудад хувь нэмэр оруулна гэж үзсэн. Үүнд: Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудад орчин үеийн судалгаанд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах; салбарын судлаачдад татвараас зайлсхийх байдалд нөлөөлсөн хүчин зүйлүүдтэй холбоотой судалгааг үргэлжлүүлэх; бодлого боловсруулагчдад аж ахуйн нэгжүүдийн татварын тайлагнал болон татварын хуулийн хэрэгжилтийг хангуулахад судалгаанд суурилсан бодлого боловсруулах боломжийг тус тус бий болгох явдал юм. Бид дараагийн хэсэгт түүвэр сонголт болон судалгааны үр дүнг, гуравдугаар хэсэгт үндсэн үр дүнг танилцуулахаар бэлтгэлээ.

#### Судалгаа

Бид судалгаандаа манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжийн олон жилийн мэдээллийг хамруулахыг зорьсон. Иймд Сангийн Яамны цахим тайлангийн системд

санхүүгийн тайлангаа тогтмол илгээж буй аж ахуйн нэгжүүдийг судалгааны түүврээр сонгон тэдгээрийн 2013-2019 оны санхүүгийн тайлангийн мэдээллийг авч ашигласан. 2013 онд 47,557 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байснаас долоон жилийн турш тасралтгүй санхүүгийн тайлангаа ирүүлсэн нь 37,811 байсан. Үүнээс мөн хугацааны турш тасралтгүй үйл ажиллагаа явуулсан нь 13,873 байна.

Аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийж буй байдлыг илрүүлэхийн тулд Dyreng (2008) нарын боловсруулсан аж ахуйн нэгжийн тайлант хугацаанд төлсөн татварын хэмжээнд үндэслэн тооцсон татварын үр ашигтай хувь хэмжээний загварыг сонгон ашигласан.

$$CASH ETR_i = \frac{\sum_{t=1}^N Cash Tax Paid_{it}}{\sum_{t=1}^N Pretax Income_{it}}$$

Үүнд: *CASH ETR* - аж ахуйн нэгжийн төлсөн татварын хэмжээнд үндэслэн татварын үр ашигтай хувь хэмжээг тооцох үзүүлэлт; *Cash Tax Paid* - аж ахуйн нэгжийн татварын байгууллагад төлсөн ААНОАТ-ын дүн; *Pretax Income* - санхүүгийн тайлан дах татварын өмнөх ашиг; *i* - тухайн аж ахуйн нэгжийг илэрхийлэх индекс; *t* - тухайн тайлант оныг илэрхийлэх индекс.

Энэхүү загвар нь урт хугацаанд татвараас зайлсхийж буй байдлыг илрүүлэх зорилготой бөгөөд татварын үр ашигтай хувь хэмжээний тайлбарлах чадварыг нэмэгдүүлэхийн тулд хуваарийн утгыг эерэг байхыг шаардана (Dyreng, 2008). Энэ нь тухайн аж ахуйн нэгжийн он тус бүрийн санхүүгийн тайлан дах татварын өмнөх ашиг тэгээс их ба тэдгээрийн нийлбэрээр нийт татварын өмнөх ашгийн дүнг тодорхойлох явдал юм. Уг шаардлагын дагуу судалгааны түүвэрт татварын өмнөх ашиг тэгээс их буюу

## Хүснэгт 1. CASH ETR-ийн тархалт

Үзүүлэлт	CASH ETR1	CASH ETR3	CASH ETR6
<b>А. Түүвэр</b>			
Аж ахуйн нэгжийн тоо	2,853	2,853	2,853
Түүврийн тоо	17,118	5,706	2,853
<b>Б. Тархалт</b>			
Дундаж	0.134	0.128	0.127
Стандарт хазайлт	0.144	0.120	0.113
5 дахь персентил	0.034	0.059	0.063
25 дахь персентил	0.099	0.100	0.100
Медиан	0.100	0.100	0.100
75 дахь персентил	0.122	0.117	0.116
95 дахь персентил	0.295	0.245	0.234

ашигтай ажилласан 6,760 аж ахуйн нэгж үлдсэнээс төлсөн татварын дүн нь тэгээс их 2,853 аж ахуйн нэгж байсан. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд төлсөн ААНОАТ-ын дүнг тооцож гаргахын тулд тайлант хугацааны татварын зардал, татварын өрийн эхний болон эцсийн үлдэгдлийн зөрүүг ашигласан учраас 2013 оны санхүүгийн тайлангийн мэдээллүүд хасагдсан. Үүний үр дүнд 2,853 аж ахуйн нэгжийн зургаан жилийн 17,118 санхүүгийн тайлангийн мэдээлэл үлдэж загварт ашиглагдсан.

Өмнөх онуудын төлөгдөөгүй татварын дүн болон урьдчилж төлсөн татварын төлбөр зэрэг нь тайлант хугацаанд төлсөн татварын дүнд багтаж байдаг учир уг нөлөөллийг багасгахын тулд татварын үр ашигтай хувь хэмжээг урт хугацаанд тооцох нь тухайн тайлант хугацааны татварын хэмжээтэй илүү уялдана гэж үзсэн. Иймд түүвэр сонголтын хугацаанаас хамаарч хамгийн уртдаа 6 жилээр татварын үр ашигтай хувь хэмжээг тооцсон болно. Хүснэгт 1-т түүвэр сонголтын тархалтыг харууллаа.


Дээр дурдсанчлан тайлант оны төлсөн татварын дүнд өмнөх оны татварын өр болон урьдчилгаа төлбөрийн нөлөө байгаа учраас татварын үр ашигтай

хувь хэмжээ богино хугацаанд их, урт хугацаанд бага буюу илүү бодитой илэрхийлэгдэх ёстойг түүвэрт сонгогдсон аж ахуйн нэгжүүдийн татварын үр ашигтай хувь хэмжээний тархалтын үр дүн батлан харуулсныг Хүснэгт 1-ээс харж болно. Тухайлбал, Хүснэгт 1-ийн Б хэсгээс татварын үр ашигтай хувь хэмжээг 1, 3 болон 6 жилээр тооцсон тархалтыг харж болох бөгөөд он тус бүрийн үзүүлэлт (CASH ETR1)-ээр тооцсон татварын үр ашигтай хувь хэмжээний дундаж болон медиан нь 13.4 ба 10.0 хувь, гурван жилийн буюу 2014-2016, 2017-2019 онуудын үзүүлэлт (CASH ETR3)-ээр тооцсон татварын үр ашигтай хувь хэмжээний дундаж болон медиан нь тус бүр 12.8 ба 10.0 хувь байна. Харин 2014-2019 онуудын буюу урт хугацааны үзүүлэлт (CASH ETR6)-ээр тооцсон татварын үр ашигтай хувь хэмжээний дундаж болон медиан нь 12.7 ба 10.0 хувь болж дундаж үзүүлэлт буурсан байна.


Зураг 1-т татварын өмнөх ашиг нь тэгээс их 2,853 аж ахуйн нэгжийн татварын үр ашигтай хувь хэмжээг 1, 3 болон 6 жилээр тооцсон гистограммыг харууллаа. Гистограммыг байгуулахын тулд түүврийг CASH ETR нь 10 хувиас бага аж ахуйн нэгжүүд, CASH ETR нь 10-аас 20 хувьтай

Зураг 1. CASH ETR-ийн тархалт, нийт аж ахуйн нэгжээр


## А. CASH ETR1-ийн тархалт



## Б. CASH ETR3-ын тархалт



## В. CASH ETR6-ийн тархалт




аж ахуйн нэгжүүд гэх мэтчилэн CASH ETR нь 60 хувиас их гэж долоон хэсэгт хуваасан. Татварын үр ашигтай хувь хэмжээ 20 хувь болон түүнээс бага аж ахуйн нэгжүүдийг татварын үр ашигтай хувь хэмжээ “бага” гэж ангилдаг. 10 болон түүнээс бага хувьтай аж ахуйн нэгжүүдийн хувьд “Red Flag” буюу тухайн байгууллагын татварын тайлагнал, татвар төлөлттэй холбоотой шийдвэрлэх асуудал байна


гэж үздэг. Харин тус хувь хэмжээ 40 хувь болон түүнээс дээш аж ахуйн нэгжүүдийг татварын үр ашигтай хувь хэмжээ “их” гэж ангилдаг (Dyrenг, 2008). Зураг 1-ийн А хэсэг татварын үр ашигтай хувь хэмжээг 1 жилээр тооцсон үр дүнг харуулах ба нийт аж ахуйн нэгжүүдийн 90 орчим хувь нь 20 болон түүнээс бага, 32 орчим хувь нь 10 болон түүнээс бага татварын үр ашигтай хувь хэмжээтэй байна. Дээрх үр дүнг 3

## Зураг 2. CASH ETR6-ийн тархалт, аж ахуйн нэгжийн хэмжээгээр

## А. Жижиг аж ахуйн нэгжийн хувьд



## Б. Бусад аж ахуйн нэгжийн хувьд



болон 6 жилээр тооцсон хувь хэмжээний тархалтын үр дүнтэй харьцуулахад хол зөрүүгүй байгааг харж болно. Тухайлбал, гурван жилээр тооцсон (Зураг 1-ийн Б хэсэг) татварын үр ашигтай хувь хэмжээ 20 болон түүнээс бага хувьтай аж ахуйн нэгжүүд нийт аж ахуйн нэгжийн 93 орчим хувь, 10 болон түүнээс бага хувьтай нь 33 орчим хувь байгаа бол зургаан жилээр тооцсон (Зураг 1-ийн В хэсэг) үр дүнгээс харахад 94 орчим хувь нь 20 болон түүнээс бага, 33 орчим хувь нь 10 болон түүнээс бага татварын үр ашигтай хувь хэмжээтэй байна. Эдгээр хувь хэмжээ хол зөрүүгүй байгаа нь нэг жилээр тооцсон татварын үр ашигтай хувь хэмжээ урт хугацаа буюу зургаан жилийн үр дүнг төлөөлөхүйц болохыг харууллаа. Энэ нь аж ахуйн нэгжүүд хэдийгээр ашигтай ажилласан ч жил бүр, цаашлаад урт хугацаандаа

татварынхаа ихэнх хэсгийг төлөхөөс зайлсхийж (бултаж) буйг илэрхийлж байгаа хэрэг юм.

Бид дээрх үр дүнг аж ахуйн нэгжүүдийн хэмжээ, байршил болон бүс нутгаарх ялгарал байгаа эсэхийг тодруулахын тулд урт хугацааны татварын үр ашигтай хувь хэмжээг (CASH ETR6) дахин тооцсон. Хэмжээгээр нь ялгаж хийсэн судалгааны үр дүнд жижиг аж ахуйн нэгжүүд бусад аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад татвараас илүү зайлсхийж буй нь харагдсан.

Үүнийг Зураг 2-ын А хэсэгт харууллаа. Тухайлбал, жижиг аж ахуйн нэгжүүдийн 95 орчим хувь нь 20 болон түүнээс бага хувийн татварын үр ашигтай хэмжээтэй байгаа бол бусад аж ахуйн нэгжүүдийн 89 орчим хувь нь уг интервалд оршиж байна. Энэ нь жижиг аж ахуйн нэгжүүд бусад аж



ахуйн нэгжүүдтэй харьцуулахад татвар төлөлт муу байгааг илтгэнэ.

Нийслэл, орон нутгаар болон бүс нутгаар нь ялгаж хийсэн судалгааны үр дүнг хавсралтаар харууллаа. Нийслэл болон орон нутгаар ялган хийсэн тооцооллын үр дүнд нийслэлийн есөн дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 91 орчим хувь нь татварын үр ашигтай хувь хэмжээ 20 болон түүнээс бага интервалд байна. Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд 95 орчим хувь нь тус интервалд оршиж байгаа нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд татвар төлөлт сайтай байгааг илтгэж байна. Харин Баруун, Хангай, Төв, Говь, Зүүн гэсэн таван бүсээр ялгаж хийсэн тооцооллын үр дүнд татварын үр ашигтай хувь хэмжээ 20 болон түүнээс бага интервалд орших аж ахуйн нэгжүүдийн тоо ойролцоо буюу 94-96 хувьтай байгаа нь бүсийн ялгаа бага байгааг харуулна.

#### Дүгнэлт

Татварын хувь хэмжээний оновчтой байдал, татварын бүртгэлийн асуудал, хууль эрх зүйн орчны таатай эсэх зэрэг асуудлуудыг хамарсан судалгааны ажлууд манай улсын хувьд нилээдгүй хийгдсэн хэдий ч аж ахуйн нэгжүүдийг татвараас зайлсхийж буй эсэхийг үнэлсэн ажил хараахан хийгдээгүй байна. Иймээс бид Dyreng (2008) нарын боловсруулсан татварын үр ашигтай хувь хэмжээний загвар ашиглан манай улсад үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдийн богино болон урт хугацаанд татвараас зайлсхийж

буй эсэхийг илрүүлэхийг зорьсон билээ. Загварын шалгуурын дагуу судалгааны түүвэрт 2,853 аж ахуйн нэгж сонгогдон үлдсэн бөгөөд эдгээр аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийж буй эсэхийг богино болон урт хугацаанд тооцож үзэхэд 93 орчим хувь нь татварын үр ашигтай хувь хэмжээ 20 болон түүнээс бага интервалд байсан. Энэ байдалд аж ахуйн нэгжийн хэмжээ, байршил, бүс нутгийн ялгаа нөлөөлж буй эсэхийг тодруулах зорилгоор урт хугацааны татварын үр ашигтай хувь хэмжээг хэсэг тус бүрээр тооцож үзсэн. Хэмжээнд үндэслэн тооцсон үр дүнд жижиг аж ахуйн нэгжүүдийн 95 орчим хувь нь татварын үр ашигтай хувь хэмжээ 20 болон түүнээс бага, харин бусад аж ахуйн нэгжүүдийн 89 орчим хувь нь уг интервалд оршиж байгаа нь жижиг аж ахуйн нэгжүүд татвар төлөлт муу байгааг илтгэж байна. Гэвч энэ нь бусад аж ахуйн нэгжүүд татвараас зайлсхийдэггүй гэсэн үг биш юм. Байршлын хувьд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн татвар төлөлт орон нутагтай харьцуулахад илүү, харин бүс нутгийн хувьд ялгаагүй байсан. Нэгтгэн дүгнэвэл улсын хэмжээнд үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үнэмлэхүй олонх нь татварынхаа ихэнх хэсгийг төлдөггүй зайлсхийдэг (бултдаг) болохыг бидний судалгааны ажлын үр дүн харууллаа. Энэхүү ажлаараа аж ахуйн нэгжүүдийн татвараас зайлсхийх байдлыг илрүүлэхийг зорьсон бөгөөд үүнд макро болон микро түвшинд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг үнэлж, тооцох ажлыг нээлттэй үлдээлээ.




## Ашигласан материал

- Blaylock, B., Shevlin, T., & Wilson, R. J. (2012). Tax Avoidance, Large Positive Temporary Book-Tax Differences, and Earnings Persistence. *The Accounting Review*, 87(1), 91-120.
- Callihan, D. S. (1994). Corporate Effective Tax Rates: A Synthesis of the Literature. *Journal of Accounting Literature*, 13, 1-43.
- Chen, K. P., & Chu, C. (2005). Internal Control versus External Manipulation: A Model of Corporate Income Tax Evasion. *The RAND Journal of Economics*, 36(1), 151-164.
- Crocker, K. J., & Slemrod, J. (2005). Corporate Tax Evasion With Agency Costs. *Journal of Public Economics*, 89(9-10), 1593-1610.
- Desai, M. A., & Dharmapala, D. (2006). Corporate Tax Avoidance and High-Powered Incentives. *Journal of Financial Economics*, 79(1), 145-179.
- Desai, M. A., Dyck, A., & Zingales, L. (2007). Theft and Taxes. *Journal of Financial Economics*, 84(3), 591-623.
- Dyreng, S. D., Hanlon, M., & Maydew, E. L. (2008). Long-Run Corporate Tax Avoidance. *The Accounting Review*, 83(1), 61-82.
- Hanlon, M., & Heitzman, S. (2010). A Review of Tax Research. *Journal of Accounting and Economics*, 50(2-3), 127-178.
- Ko, J. K., & Yoon, S. S. (2016). A Review of Empirical Tax Research in Korea. *Korean Accounting Review*, 41(3), 279-310.
- Mills, L. F. (1998). Book-Tax Differences and Internal Revenue Service Adjustments. *Journal of Accounting Research*, 36(2), 343-356.
- Shackelford, D. A., & Shevlin, T. (2001). Empirical Tax Research in Accounting. *Journal of Accounting and Economics*, 31(1-3), 321-387.
- Slemrod, J. (2004). The Economics of Corporate Tax Selfishness. *National Tax Journal*, 57(4), 877-899.
- Stickney, C. P., & McGee, V. E. (1982). Effective Corporate Tax Rates the Effect of Size, Capital Intensity, Leverage and Other Factors. *Journal of Accounting and Public Policy*, 1(2), 125-152.
- Wilson, R. J. (2009). An Examination of Corporate Tax Shelter Participants. *The Accounting Review*, 84(3), 969-999.


## Хавсралт

## CASH ETR6-ийн тархалт, нийслэл болон орон нутгаар

## А. Нийслэл




## Б. Орон нутаг




## CASH ETR6-ийн тархалт, бүс нутгаар


## А. Баруун бүс




**Б. Хангайн бүс**



**В. Төвийн бүс**



**Г. Говийн бүс**



**Д. Зүүн бүс**

